МОНГОЛ-ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛЫН ЯАМ

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/11/01 **Дуусах хугацаа:** 2026/12/01

Ажил эхлэх хугацаа: 2026/12 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн Газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

(Түр ажлын байр)

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавихад удирдлагыг хууль зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах;
- Байгууллагаас гарч буй тушаал, шийдвэр, гэрээ болон бусад баримт бичгийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд эрх зүйн хяналт хийх, шаардлагатай хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;
- Хууль зүйн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн өмнө байгууллагыг төлөөлөх;
- Байгууллагын хэмжээнд эрх зүйн болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, мэдээлэл, арга хэмжээ зохион байгуулах.

Тавигдах шаардлага:

- Хууль, эрх зүйн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
- Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Багаар болон бие даан ажиллах чадвартай байх;
- Үнэнч шударга, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй байх;
- Англи хэлний аман болон бичгийн харилцааны дундаас дээш түвшний мэдлэгтэй байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар – CV
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа – 2 хувь

Холбоо барих:

Та баримт бичгээ англи эсхүл монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn
Утас: +976-7023 2090

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.